

# Сэдэв: Төмөр замын ТЭЭВЭРЛЭЛТ



- Олон улсын ачаа тээвэрлэлтэд төмөр замын тээвэр томоохон байр суурь эзэлдэг. Төмөр замын тээвэр нь хуурай замын тээврийн төрөл хэлбэрүүдийн дотроос их хэмжээний ачааг харьцангуй богино хугацаанд, харьцангуй бага зардлаар тээвэрлэх боломжийг олгодгоороо давуутай юм.
- Гэхдээ төмөр замын тээвэр нь тусгайлан зассан замыг хэрэглэдэг, ачааг “хаалганаас хаалганд” хүргэж чаддаггүй зэрэг сул талуудтай. Түүнчлэн төмөр замын тээвэр үйл ажиллагааны нарийн чанд технологийг шаарддаг, цаг хугацааны нарийвчилсан хуваарийн дагуу явагддаг.



Төмөр замын тээвэрт битүү вагон, хагас вагон, тавцант болон тусгай зориулалтын цистерн, бункер, танкер зэрэг вагоноор ачааг тээвэрлэхээс гадна цаг агаарын халуун хүйтнээс хялбар муудах ачааг хөргүүртэй болон тогтмол дулаантай вагоноор, үнэ цэнэтэй ачааг харуул хамгаалалттай тээвэрлэх зэргээр тээвэрлэлтийн олон хэлбэрийг санал болгож чаддаг.



- Тээвэрлэлтийн явцад сэлгэн ачилт бага. Хол зайд их хэмжээний бараа тээвэрлэхэд тохиромжтой
- Тээврийн зардал хямд
- Бараа бүтээгдэхүүнийг хурдан хугацаанд тээвэрлэх боломжтой
- Аюулгүй байдлыг сайн хангадаг
- Цаг агаарын нөлөөлөл байхгүй
- Агаарын бохирдолт бага, замын хувьд аюул багатай
- Тээвэрлэх зай хол байх тусам тээврийн зардал багасна

- Галт тэрэгний хуваарь зэрэг өөрийнх нь онцлогоос шалтгаалж цаг их шаардана
- Үйлдвэрлэгчийн үйлдвэрээс шууд ачилт хийх боломж хязгаарлагдмал
- Тусгайлсан зам чиглэлд тээвэрлэлт хийх боломжтой
- Ачилт буулгалт хийх цэг нь үйлдвэрлэгч эсхүл худалдан авагчаас алслагдсан байх нь түгээмэл

- “Зорчигч тээвэрлэх олон улсын сүлжээний тухай” 1951 оны хэлэлцээр
- “Ачаа тээвэрлэх олон улсын сүлжээний тухай” 1951 оны хэлэлцээрүүдэд нэгдэн орсон бөгөөд манай төмөр замын олон улсын тээвэрлэлтэд мөрдөж буй эрх зүйн хамгийн чухал баримт бичиг юм

- Ачилтыг төлөвлөх, ачааг хүлээн авах
- Ачилтыг хийх, ачааг жигнэх болон хэмжих
- Ачаа гээгдсэн ба гээгдсэн ачаа олдсон тохиодолд илгээгчид мэдэгдэх журам, гээгдсэн ачааны хохирлыг барагдуулах
- Хүлээн авагчид мэдэгдэх
- Ачааг хүлээлгэн өгөх
- Тээвэрлэлтийн аюулгүй нөхцлийг хангасан байдлыг тогтоох
- Өмчлөх эрхийг тогтоох зэрэг төмөр замын тээвэрлэлттэй холбоотой бүхий л нөхцлийг зохицуулдаг



- Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг экспортлогчдын хувьд Замын-Үүд болон Сүхбаатар зэрэг хилийн өртөөдөөр БНХАУ болон ОХУ-г холбосон төмөр замаар дэлхийн аль ч улс руу экспорт, импорт, транзит ачааны бүх тээврүүдийг хийх боломжтой.
- Тухайлбал →



## Хятадын чиглэл:

Хятадын Синган боомт нь Монголд хамгийн ойрхон далайн гарц бөгөөд Монголын Замын-Үүд өртөөтэй төмөр замаар шууд холбогддог. Уг далайн гарцыг ашиглан импорт, экспортын тээвэрлэлтийг, Хятадын төмөр замаар дамжин БНХАУ-ын төмөр замын бүх өртөө, боомт, хотуудаас болон тус газруудад ачаа тээвэрлэлтүүдийг зохион байгуулах бүрэн боломжтой.



## *Оросын чиглэл:*

Транссибирийн төмөр замаар дамжин ОХУ-ын Санкт-Петербург, Өмнөд Архангельск, Владивосток, Новороссийск боомтууд болон Европын холбооны бүх улсуудтай холбогддог. Оросын Владивосток боомтоор Өмнөд Ази, Төв болон Өмнөд Америк, Европыг, Оросын Санкт-Петербург боомтоор Европ, Америкийг, Оросын Новороссийск боомтоор Ойрхи Дорнод, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудтай тус тус холбогддог.



# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

